



I-III/2022

Тархаасан: 2022 оны 6 дугаар сарын 13



2022 оны 1 дүгээр улирлын байдлаар ААНБ-ын ажиллагчдын сарын медиан цалин 1066.7 мянган төгрөг байна

Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 46.9 мянган аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын 717.7 мянган ажиллагч хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) төлж буй ААНБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 2.0 (4.4%) мянгаар, өмнөх улирлаас 569 (1.2%)-өөр, ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 35.7 (5.2%) мянгаар өссөн бол ажиллагчдын тоо өмнөх улирлаас 1.5 (0.2%) мянгаар буурчээ.

ХҮСНЭГТ 1. НДШ ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАНД ХАМРАГДСАН ДААТГУУЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2020 I-III	2021 I-III	2022 I-III
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	17 210	17 096	17 855
Уул уурхай, олборлолт	36 805	38 399	40 048
Боловсруулах үйлдвэрлэл	68 241	72 091	73 376
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	12 996	13 843	14 163
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7 878	8 718	8 743
Барилга	41 896	42 710	45 766
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	82 405	86 443	98 904
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	39 438	42 960	42 074
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	15 498	13 793	15 625
Мэдээлэл, холбоо	14 396	15 042	17 412
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	27 883	27 470	29 322
Үл хөдлөх үйл ажиллагаа	2 492	2 844	3 188
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	20 804	21 538	23 153
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	24 229	24 479	25 348
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	77 435	78 179	79 053
Боловсрол	100 589	104 230	108 245
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	42 700	44 432	46 718
Урлаг, үзвэр, тоглоом наадам	7 850	7 817	8 219
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	17 905	17 314	18 070
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	486	531	740
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2 203	2 136	1 718
Бүгд	661 339	682 065	717 740


Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан нийт даатгуулагчийн 108.2 (15.1%) мянга нь боловсролын салбарын, 98.9 (13.8%) мянга нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарын, 79.1 (11.0%) мянга нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарын, 73.4 (10.2%) мянга нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын, 46.7 (6.5%) мянга нь хүний эрүүл

мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын, 45.8 (6.4%) мянга нь барилгын салбарын, 42.1 (5.9%) мянга нь тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын, 40.0 (5.6%) мянга нь уул, уурхай олборлолтын салбарын, 29.3 (4.1%) мянга нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын, 154.2 (21.4%) мянга нь бусад салбарын ажиллагчид байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2022 оны 1 дүгээр улирлын тайланд хамрагдсан 717.7 мянган ажиллагчдын сарын медиан цалин 1066.7 мянган төгрөг байна. Медиан цалин өмнөх оны мөн үеэс 120.9 (12.8%) мянган төгрөгөөр өссөн бол өмнөх улирлаас 1.4 (0.1%) мянган төгрөгөөр буурчээ.

Нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 1450.1 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 135.2 (10.3%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 11.9 (0.8%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

ЗУРАГ 1. ААНБ-ЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН БОЛОН МЕДИАН ЦАЛИН, УЛИРЛААР, МЯНГАН ТӨГРӨГӨӨР




Дундаж цалинг хүйсээр авч үзвэл, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар эрэгтэйчүүдийнх 1.6 сая, эмэгтэйчүүдийнх 1.3 сая төгрөг байна.

Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын цалин хамгийн их буюу 3.5 сая төгрөг, урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт ажиллагчдын цалин хамгийн бага буюу 919.1 мянган төгрөг байна.


ААНБ-д ажиллагчдын сарын дундаж нэрлэсэн цалин 2022 оны 1 дүгээр улиралд 2015 оноос 67.0 хувиар нэмэгдсэн хэдий ч худалдан авах чадварыг илэрхийлэх бодит цалин 13.4 хувиар нэмэгджээ.

ЗУРАГ 2. БОДИТ ЦАЛИНГИЙН ИНДЕКС (2015=100), улирлаар, хувиар




Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан нийт даатгуулагчийн дотор 700.0 мянгаас 1.1 сая төгрөгийн цалинтай даатгуулагчийн эзлэх хувь хамгийн их буюу 25.2 хувь, харин 3.0 саяас дээш төгрөгийн цалинтай даатгуулагчийн эзлэх хувь хамгийн бага буюу 7.1 хувь байна.

ЗУРАГ 3. АЖИЛЛАГЧИД, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар, цалин хөлсний бүлгээр, дүнд эзлэх хувиар



Ажиллагчдын тооны бүлгээр авч үзэхэд 1-9 ажиллагчтай ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин 907.8 мянган төгрөг, 10-49 ажиллагчтайнх 1.2 сая төгрөг, 50-99 ажиллагчтайнх 1.3 сая төгрөг, 100-199 ажиллагчтайнх 1.5 сая төгрөг, 200 ба түүнээс дээш ажиллагчтайнх 2.0 сая төгрөг байна.

ЗУРАГ 4. АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, ажиллагчдын тооны бүлгээр, мянган төгрөгөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар



Ажиллагчдын сарын дундаж цалинг бүсээр авч үзэхэд Баруун бүсэд 982.9 мянган төгрөг, Зүүн бүсэд 1.1 сая төгрөг, Төвийн бүсэд 1.3 сая төгрөг, Хангайн бүсэд 1.4 сая төгрөг байгаа нь улсын дунджаас 82.1-467.2 (5.7%-32.2%) мянган төгрөгөөр бага байна. Харин Улаанбаатар хотод ажиллагчдын сарын дундаж цалин 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 1.6 сая төгрөг болж, улсын дунджаас 110.5 (7.6%) мянган төгрөгөөр их байна.


ЗУРАГ 5. АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар, бүсээр, мянган төгрөгөөр



Байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл болон хязгаарлагдмал хариуцлагатай компанид ажиллагчдын сарын дундаж цалин 1.5 сая төгрөг, хувьцаат компанид ажиллагчдын сарын дундаж цалин 1.7 сая төгрөг, төрийн өмчит үйлдвэрийн газар болон бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлд ажиллагчдын сарын дундаж цалин 1.9 сая төгрөг байгаа нь улсын дунджаас 1.3-479.8 (0.1%-33.1%) мянган төгрөгөөр их байна.

Харин хоршоонд ажиллагчдын дундаж цалин 751.3 мянган төгрөг, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллага болон төрийн бус байгууллагад ажиллагчдын дундаж цалин 1.2 сая төгрөг байгаа нь улсын дунджаас 245.0-698.7 (16.9%-48.2%) мянган төгрөгөөр бага байна. Төсөвт байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин өмнөх оны мөн үеэс 122.0 (11.6%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

ЗУРАГ 6. АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН БОЛОН АЖИЛЛАГЧДЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар, байгууллагын хариуцлагын хэлбэрээр, мянган төгрөгөөр



Ажиллагчдын сарын дундаж цалинг ажил, мэргэжлийн ангиллаар авч үзэхэд 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагчийн сарын дундаж цалин хамгийн их буюу 1.8 сая төгрөг, харин хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтны цалин 818.8 мянган төгрөг буюу хамгийн бага байна.

Ойлголт, тодорхойлолт:

Цалин хөлс нь: Үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, ажиллаагүй цагийн олговор болон бусад олговроос бүрдэх бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татвар суутгахаас өмнөх буюу нэрлэсэн цалин хөлс юм.

Жишээ нь: Иргэн Э-гийн бодогдсон цалин 1 450 087 төгрөг гэж үзээд, гарт олгох цалинг тооцоход 1,170,994 төгрөг болж байгааг доорх зурагт харууллаа.



Дундаж цалин хөлс нь тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

$$\bar{x} = \frac{\sum_{i=1}^n (w_i * x_i)}{\sum_{i=1}^n w_i}$$

\bar{x} – Дундаж цалин хөлс

x_i – Ажиллагчдын нийт цалин хөлс

w_i – Ажиллагчдын тоо

Нэрлэсэн цалин нь хэрэглээний үнийн индексээр засварлагдаагүй, худалдан авах чадварын өөрчлөлтийг илэрхийлдэггүй бөгөөд татвар суутгал хасагдаагүй цалин, хөлс юм.

Нэрлэсэн цалингийн индекс нь тайлант болон суурь хугацаа (жил, улирлын)-ны нэрлэсэн дундаж цалин хөлсний хувиар илэрхийлсэн харьцаа байна.

Бодит цалин нь нэрлэсэн цалингийн хэрэглээний үнийн индексээр засварлагдсан, худалдан авах чадварын өөрчлөлтийг илэрхийлсэн үзүүлэлт юм.

Бодит цалингийн индексийг тооцохдоо нэрлэсэн цалингийн индексийг, тайлант хугацааны хэрэглээний үнийн индексэд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

Медиан цалин нь ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр байршуулсан цувааг таллан хувааж байгаа ажилтны цалин юм.



Ажиллагчдын тоо тэгш тоо байвал:

$$M_e = \frac{n}{2} + 1$$

Хэрэв ажиллагчдын тоо сондгой тоо байвал:

$$M_e = \frac{n + 1}{2}$$

M_e – Цувааны төвд орших ажилтны цалин

n – Нийт ажиллагчдын тоо



Эх үүсвэр:

Нийгмийн даатгалын ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 7 дугаар сарын 19

Нэгдсэн статистикийн газрын дарга
Э.Эрдэнэсан
Утас: (976-51)-266414

Нийгмийн статистикийн газрын ахлах
статистикч Н.Должинсүрэн
Утас: (976-51)-263966



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212